



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 2/29

Хэрлэн сум

Малын өвс тэжээлийн үнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, Мэргэжлийн хяналтын дүгнэлт, аймгийн Засаг даргын Зөвлөл, аймгийн Онцгой комиссын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017-2018 оны мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд орон нутгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн рапсын болон улаан буудайн таримал ногоон тэжээлийн үлдэгдлийн нэг бүрийн үнийг 100 хувь чөлөөлсүгэй.

2. Рапсын болон улаан буудайн таримал ногоон тэжээлийн үлдэгдлийн тоо ширхэг, 2018-2019 оны мал өвөлжилтийн бэлтгэлд орон нутгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн малын өвс, тэжээлийн худалдах үнийг хавсралтаар баталсугай.

3. Орон нутгийн аюулгүйн нөөцийн өвс тэжээлийг тогтоосон үнээр малчдад худалдан борлуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Нямдаваа, Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа Н.Чанцал нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



01/ Аймгийн Засаг даргын 2019 оны
дүгээр сарын 21 өдрийн 2109
дугаар захирамжийн хавсралт



ӨВС ТЭЖЭЭЛИЙН ҮНЭ

№	Тэжээлийн нэр төрөл	Бэлтгэсэн он	Тоо ширхэг \боодол\	Нэг бүрийн үнэ
1	Рапсын таримал ногоон тэжээл	2017	8951	0
2	Улаан буудайн тэжээл	2017	560	0
3	Рапсын таримал ногоон тэжээл	2018	4751	8420
4	Өвс	2018	11000	5000